



**МОНГОЛ УЛСЫН  
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА  
ХОЛБООНЫ САЙД**

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160  
Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,  
Цахим шуудан: info@mddc.gov.mn  
Цахим хуудас: www.mddc.gov.mn

2023.01.27 № 01/200  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тайлан хүргүүлэх тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 374 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ыг үндэслэн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн 2022 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ..... хуудастай.



НУУЦРАЛ

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын  
2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн  
01/200 дугаар албан бичгийн хавсралт

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМАНД ХАМААРАХ  
“ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН  
ХЭРЭГЖИЛТ”-ИЙН БИЕЛЭЛТИЙН ТУХАЙ**

2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО,  
ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Засгийн газрын үйл ажиллагаа дахь Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын 6.3 дахь хэсгийг үндэслэн хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн ерөнхий дүнг гаргахдаа зорилт, арга хэмжээ, зүйл, заалт бүрийн хэрэгжилтийн арифметик дунджаар тооцож, үнэлгээг үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

**ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН**

Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах Монгол Улсын 9 хуулийн хэрэгжилтийн хүрээнд 79 заалт, Улсын Их хурлын 5 тогтоолын хүрээнд 7 заалт, Улсын Их Хурлын байнгын хорооны 1 тогтоолын хүрээнд 10 заалт, Ерөнхийлөгчийн 7 зарлигийн хүрээнд 11 заалт, Үндэсний аюулгүй байдлын 2 зөвлөмжийн хүрээнд 2 заалт, Засгийн газрын 12 тогтоолын хүрээнд 12 заалт, Ерөнхий сайдын 1 захирамжийн хүрээнд 1 заалт, Засгийн газрын хуралдааны 19 тэмдэглэлийн хүрээнд 25 заалт, Засгийн газрын 3 албан даалгаврын хүрээнд 9 заалт буюу нийт 59 шийдвэрийн 156 заалтын биелэлтэд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан.

156 заалт бүхий хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар тус яамны газар, хэлтэс тус бүр хариуцсан ажил үүрэг, чиглэлийн дагуу тайлагнаж, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үр дүн гарлаа.

1. Бүрэн хэрэгжсэн буюу 100%-ийн биелэлттэй – 91
2. Хэрэгжих шатандаа буюу 70%-ийн биелэлттэй – 41
3. Хэрэгжилт хангалтгүй буюу 30%-ийн биелэлттэй – 4
4. Хэрэгжээгүй буюу 0%-ийн биелэлттэй - байхгүй
5. Хугацаа болоогүй буюу Х.Б тэмдэглэгээтэй – 20 заалт байна.



Дээрх хугацаа болоогүй 20 заалтын 18 заалтын хувьд хэрэгжилт бичих боломжгүй, үнэлэх боломжгүй буюу тус яаманд хамаарах ажил биш тул хасуулах саналыг тусгасан болно.

**Хүснэгт:** Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2022 оны жилийн эцсийн тоон үзүүлэлт

Д/д		Нийт	МУ-ын хууль	УИХ-н тогтоол	УИХ-н байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ЗГ-н тогтоол	ЗГ-н хуралдааны тэмдэглэл	ЗГ-н албан даалгавар	Ерөнхий сайдын захирамж	ҮАБ-н зөвлөмж	ҮАБЗ-н хуралдааны	ЗГХЭГ-н даргын
1	Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	60	9	5	1	7	12	20	3	1	2	-	-
2	Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	156	79	7	10	11	14	28	4	1	2	-	-
3	Бүрэн хэрэгжсэн 100%	100%	91	57	6	7	8	4	7	1	-	1	-
4	Хэрэгжих шатанд	70%	41	13	-	2	1	7	15	2	1	-	-
5	Хэрэгжилт хангалтгүй	30%	4	-	-	-	-	1	3	-	-	-	-
6	Хэрэгжээгүй	0%	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
7	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	х.б	20	9	1	1	2	2	3	1	-	1	-
	Биелэлтийн дундаж	88.9 %	94.3 %	100 %	93.33 %	96.67 %	76.67 %	73.6 %	80 %	70 %	100 %	-	-

УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр Цахим хөгжлийн сайдад үүрэг болгосон заалт бүрийг хяналтад авч ажиллаа. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн байдалд сар бүр хяналт тавин хийн яамны газар, хэлтсийн ажлын үр дүнг үнэлэх үзүүлэлт болгон ашиглаж байна.

Монгол улсын УИХ-аас баталсан Цахим хөгжлийг дэмжих багц хуулиуд болох Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуулийг 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан даган гарах журмуудыг боловсруулан батлуулах дэд ажлын хэсгүүд байгуулагдаж тус тусын ажил үүргийн дагуу амжилттай ажиллаж одоогоор нийт 37 дүрэм, журам, аргачлал батлуулахаас 2022 оны 12 дугаар сарын байдлаар 20-ны өдрийн байдлаар нийт 19-ийг нь батлуулж, 14 төсөлд санал авч байна. Үлдсэн 4 журмын төсөл боловсруулагдах шатанд байна.

### ГУРАВ. ДҮГНЭЛТ

2022 оны жилийн эцсийн байдлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дундаж 88.38% хувьтай дүгнэгдлээ.

Санхүүжилт удаашралтай, урт хугацааны туршид хэрэгжих болон зохион байгуулалтаас шалтгаалсан тул 4 заалтын хувьд хэрэгжилт хангалтгүй гэж үнэлсэн болно. Үүнд



1. Засгийн газрын 2022 оны “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 419 дүгээр тогтоолын 5-д “Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдынхаа 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогын чиглэл баримталж, үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллахыг засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай” гэж заасан ажлын хувьд тус яамнаас харьяа байгууллагуудад албан хаагчдынхаа 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогын чиглэл баримталж, үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллахыг чиглэл болгон ажиллаж байна.

2. 2022 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр 44 дүгээр тэмдэглэлийн II.2-т “Их өгөгдлийн (big data) сан байгуулах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох талаар Үндэсний статистикийн хороотой хамтран холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд нарт даалгав” гэж заасан ажлын хувьд “1.Төрийн их өгөгдлийн сан байгуулах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох зорилгоор үндэсний өгөгдлийн талаар баримтлах чиглэл боловсруулах, нийтийн мэдээллийн сангийн мета өгөгдлийн системийг үүсгэх шийдэл боловсруулах ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2022 оны 12 дүгээр сарын 07-ны өдрийн А/84, А/209 тушаалаар байгуулж, ажиллах удирдамжийг боловсруулан батлуулсан.Тус ажлын хэсэг нь Монгол Улс дахь их өгөгдлийн суурь нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, олон улсад хэрэгжүүлж буй дэвшилтэд технологийг нэвтрүүлэх, өгөгдлийн нийцтэй байдал, өгөгдлийн урсгалын зургийг гаргах зэрэг ажлыг эхлүүлээд байна. 2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.27 дахь заалт болон Төрийн их өгөгдөл бүрдүүлэх, бодлого, шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд ил тод, хүртээмжтэй болгох бодлогын хүрээнд төрийн захиалгаар хийгдсэн судалгааны нэгдсэн платформыг хөгжүүлж, ашиглах үүрэг бүхий ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/88 дугаар тушаалыг батлуулсан. 3. Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2022 оны А/79, А/193 тушаалаар Статистикийн үйл ажиллагаанд хамаарах нийтийн мэдээллийн сангийн нэгдсэн ангилал кодын тайлбарыг баталсан. 4. Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем ([www.opendata.gov.mn](http://www.opendata.gov.mn))-г хөгжүүлж, 56 байгууллагын 554 нээлттэй өгөгдлийн бүрдлийг байршуулаад байна.” Гэж тайлагнасан бөгөөд тус яамны хувьд өөрөөс шалтгаалах ажлуудыг боломж бололцоогоороо биелэлтийг ханган ажиллаж байгаа боловч зохион байгуулалтын улмаас хэрэгжилт хангалтгүй удаашралтай байна.

3. Засгийн газрын 2022 оны 09 үгээр сарын 28-ны өдрийн 47 дугаар тэмдэглэлээр өгөгдсөн IX.1.12д-д “Зам, тээврийн удирдлагын ухаалаг систем”-ийн бүрэлдэхүүн болох автотээврийн хэрэгслийн гэрчилгээг цахимжуулах ажлыг 2023 оны I дүгээр улиралд багтаан зохион байгуулж, мөн оны 4 дүгээр сарын 3-ны өдрөөс дагаж мөрдүүлэхийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгасан заалтын биелэлтийн хувьд “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооноос ирүүлсэн түгжрэлийг бууруулах ойрын болон дунд хугацаанд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах саналыг боловсруулж, 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/2017 дугаар албан бичгээр хүргүүлсэн.Нийслэл хот руу орж, гарч байгаа тээврийн хэрэгслээс авто зам ашигласны төлбөр авдаг уламжлалт төлбөрийн харилцааг халж,



товчоодын ажилтны цалингийн зардал, орон тоог хэмнэх, түүнчлэн тээврийн хэрэгслийн нэвтрэх хугацааг 10 дахин багасгаснаар дараалал, түгжрэл үүсгэхгүйгээр гурван секундэд нэвтэрч гарах боломж олгох шинэ системийг Улаанбаатарын шалган нэвтрүүлэх найман товчоонд суурилуулаад байгаа ба голлон хэрэгжүүлэх байгууллагын зохион байгуулалтаас шалтгаалан хэрэгжилтийн явц удаашралтай байгааг тэмдэглэх нь зүйтэй байна.

4. Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр 45 дугаар тэмдэглэлийн ХХ.4.3-д “Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг нүүлгэн шилжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг жигдрүүлэх, байр ашиглахад шаардагдах зардлын тооцоог нарийвчлан гаргаж, улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгав” гэж үүрэг өгсөн бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг нүүлгэн шилжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг жигдрүүлэх, байр ашиглахад шаардагдах зардлын тооцоог гаргасан боловч санхүүжилтийн улмаас хэрэгжилт удаашралтай байна.

ХШУДАГ-аас хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ үр дүн суурилсан, нотолгоонд тулгуурласан байх зарчмыг баримталлаа.

Нийт 156 заалтын дагуу тайланг нэгтгэж хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилтийн дундаж нь 88.9%-тай үнэлэгдлээ.

Мөн Хангалтгүй хэрэгжилттэй ажлуудыг эрчимжүүлэх талаар тодорхой төлөвлөгөө гарган ажиллах шаардлагатайг дүгнэж байна.

#### **ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /**

Хууль тогтоомж, тогтоол **шийдвэрийн** нийт 59 шийдвэрийн 156 заалтын хувьд үүрэг даалгавар өгсөн хугацаа тодорхой байгаа боловч, зарим заалтын хувьд хэзээ гүйцэтгэж дуусгавар болох хугацааг тусгаж өгөөгүйгээс тухайн жилд хийж гүйцэтгэсэн байдлаар үнэлгээг хийлээ. Зарим шийдвэрийн биелэлтийн хувьд өгөгдсөн үүрэг даалгавартай нийцэлгүй байдлаар тайлагнасан тохиолдлууд гарсан.

Иймд цаашид биелэлтийг гаргахдаа ойлгомжтой, тодорхой гаргаж хэвшихийг газар хэлтсийн дарга нар анхаарах шаардлагатайг цохон, газар хэлтэс тус бүрд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Бодлого, төлөвлөлтийн газар, Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудад:

1.Дотоод нэгждээ хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, стратеги төлөвлөгөөний хэрэгжилт гэх мэт хэрэгжилтийн биелэлтийг нэгж дотроо нэгтгэн гаргаж байх албан хаагчдыг тодорхойлж, хариуцах эзэнтэй байхаар зохион байгуулах;

2.Төсвөөс шалтгаалах ажлын биелэлтийг бодит, дүн шинжилгээтэй, баримтад тулгуурласан байдлаар гаргаж хэвших;

3.Биелэлтийг зөвхөн яамны хэмжээнд бус харьяа байгууллагуудын нэмэлт мэдээллийг авч тусгаж хэвших;

4.Нэгжийн албан хаагчид үр дүнд суурилсан бодит нотолгоонд тулгуурласан тайлан бичиж ирүүлэх;

5.Төрийн захиргааны тайлан мэдээ нэгтгэж буй албан хаагчид биелэлтийг заасан хугацаанд шуурхай өгч хэвших;

6.Тайланг 2000 тэмдэгтээс хэтрүүлэхгүй, зөв бичгийн алдаагүй, тодорхой, ойлгомжтой, эцсийн байдлаар хянагдсан засваргүй тайланг заасан хугацаанд тайлагнаж хэвших;

7.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийг мөрдлөг болгон эрчимжүүлэх шаардлагатай ажлуудад анхаарлаа хандуулж, ажил тус бүрийн биелэлтийг ахиулахад шат дараалалтай арга хэмжээ авч ажиллана уу.

Төрийн захиргааны удирдлагын газарт:

1.Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоолын дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тайлантай танилцаж холбогдох баримт материалыг судлан үзэх, үнэлгээ хийх, удирдлагын зөвлөлд танилцуулах зэрэг боломжит хугацааг анхаарч тайлагнаж хэвших;

2.Тайлан нэгтгэлийг хариуцаж буй албан хаагч удирдлагаар баталгаажуулсан эцсийн тайланг өгч хэвших;

3.Бодлогын баримт бичгийн тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг харгалзан бичсэн тайлан өгч хэвших;

4.Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчийн эрх үүрэгтэй танилцан хамтран ажиллахыг цаашид анхаарна уу.

Жич: Яамны газар, хэлтсийн дарга нар дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, нэгжийн албан хаагчдаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхэд төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг хийх болохыг үүгээр мэдэгдэж байна.

Мөн эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрхэн ахиулах болон тайлагнах талаар Төрийн захиргааны удирдлагын газрын холбогдох албан хаагч, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын албан хаагчдаас тухай бүр зөвлөгөө, дэмжлэг авч ажиллахыг хүсье.